



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.09.01 № 1366

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИХ ИРГЭН Г.САНЧИР
ТАНАА

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Гантөмөрийн Санчирын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, "Алсын хараа 2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Иргэн Гантөмөрийн Санчирын нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн мөрийн

хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Гантөмөрийн Санчирын сонгуулийн мөрийн хөтөлбөр (2. хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б. НОМИНБААТАР



**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
2020 ОНЫ СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Г.САНЧИРЫН
“УЛААНБААТАР 2020-2024” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020.07.20

Улаанбаатар хот

2020-2024 оны хооронд Нийслэл Улаанбаатар хотын хөгжүүлэхэд шаардлага бодлогын шийдэлд зайлшгүй байх шаардлагатай бодлогын зорилтуудыг товч тодорхойлон НИТХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр болгон иргэд, сонгогчид та бүхэнд өргөн барьж байна.

Зорилт 1: Нийслэл хотыг иргэндээ ээлтэй, аюулгүй, амар тайван хот болгохын төлөө чармайн ажиллах болно. Үүний тулд:

- 1.1. Хот төлөвлөлтийн бодлогыг иргэн, айл өрхөд ээлтэй байхаар тооцон, хэсэгчлэн дахин төлөвлөх замаар орчныг иргэн, айл өрх аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлд нийцүүлнэ.
- 1.2. Орчны бохирдол, агаарын бохирдлыг бууруулах асуудлаар их сургуулиудын судалгааны хүрээлэн, бизнесийн байгууллагуудтай хамтран ажиллаж агаарын бохирдлыг эх үүсвэрийг арилгах, бууруулах арга хэмжээг үе шаттай авна.
- 1.3. Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх замаар агаарын чанарыг дээшлүүлэх талаар 1 иргэн 10 мод хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.4. Хог хаягдлын асуудлаар цогц шийдэл гаргаж, хог бий болохоох дахин боловсруулах, устгах хүртэлх хогны менежментийг цогцоор нь шийдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.5. Улаанбаатар хотыг камержуулах байдлаар гэмт хэрэг, зөрчлөөс сэргийлэх бодлогыг үргэлжүүлэн, айдасгүй, амгалан хот болгох алхамд нэгдэнэ.

Зорилт 2: Төрийн шийдвэр нь хүнд сурталгүй, уян хатан байж, иргэдээ мэдээллээр хангасан, чирэгдэлгүй, шуурхай харилцах, үйлчилгээний ухаалаг шийдлийг нэвтрүүлсэн ухаалаг Улаанбаатарыг бий болгохын төлөө санаачилгатай ажиллана. Үүний тулд:

- 2.1. Төрийн үйлчилгээнд иргэдээс мэдээлэл, санал, гомдол хүлээн авах системийг илүү уян хатан, боловсронгуй болгож, иргэнээ сонсдог төрийг бий болгоход хувь нэмрээ оруулна.
- 2.2. Төрийн байгууллагын “нэгдсэн дата төв”-ийг байгуулах замаар байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэнд үйлчлэх төрийн үйлчилгээг сайжруулах цахим засаглалыг хэрэгжүүлнэ.
- 2.3. Төрийн шийдвэр гаргах системд иргэдийг оролцуулах боломжийг цахим хэлбэрээр шийдэж, иргэн төвтэй шийдвэр гаргах боломжийг бүрдүүлнэ.
- 2.4. Иргэд төрд тавих хяналтыг сайжруулахын тулд төрийн мэдээллийг илүү нээлттэй шилэн болгох боломжийг бүрдүүлнэ.
- 2.5. Хиймэл оюун ухаан ашиглах замаар төрийн нийтийн үйлчилгээ болох халуун хүйтэн усны хангамж, бохир ус зайлуулах, хог хаягдлын менежмент, цахилгаан зэрэгт илүү ухаалаг шийдлийг хэрэгжүүлнэ.



Зорилт 3: Иргэн, айл өрх бүр орлоготой, ажилтай байх нөхцөлийг бүрдүүлсэн ажил хэрэгч Улаанбаатар хөтөлбөрийг хэрэгжүүлж, бизнес эрхлэх таатай орчин бүхий нийслэлийг бий болгоход манлайлан ажиллана. Үүний тулд:

- 3.1. ЖДҮ үйлдвэрлэл эрхлэх урт хугацаат хөнгөлөлттэй зээлийн шалгуурыг иргэн илүү таатай болгох, сонгон шалгаруулалтыг нээлттэй, илүү оновчтой болгох замаар жинхэнэ эзэндээ очих нөхцөлийг бүрдүүлнэ.
- 3.2. Старт-Ап Улаанбаатар хөтөлбөр хэрэгжүүлж, инноваци, крийтив, инженерингийн чиглэлийг старт-апуудыг дэмжих төвүүдийг байгуулах, тэтгэлэгт хөтөлбөр хэрэгжүүлэх тогтолцоог гадаадын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран бий болгоно.
- 3.3. Төрийн зүгээс бий болгож буй хүнд суртлыг бууруулах, олон давхардсан тусгай зөвшөөрлүүдийг багасгах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 3.4. Төрийн хүнд суртлыг бууруулах, төвлөрлийг сааруулахын тулд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд төрийн байгууллагын зарим чиг үүргийг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх боломжийг судлан үе шаттай хэрэгжүүлнэ.
- 3.5. Нийслэл, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийг намын төлөөлөл бус иргэний төлөөлөл байх тогтолцоонд шинэ алхам хийж, иргэд, сонгогчдод үйлчлэх, тайлагнах, дэмжин ажилладаг тогтолцоог бий болгоно.

Зорилт 4: Боловсролтой, мэдлэгтэй, эрүүл иргэн бүхий мега хот болохын төлөө эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын чанар хүртээмжийг дээшлүүлэхэд гол зорилт дэвшүүлэн ажиллана. Үүний тулд:

- 4.1. Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг салбарын шилдэг менежерүүдийн дунд сонгон шалгаруулалт хийх замаар улс төрийн томилгооноос ангид байх зарчмыг санал болгон ажиллана.
- 4.2. Багшийг дэмжих төв байгуулж, баг нарын мэдлэг, ёс зүй, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэн, заах арга барилд дэвшил гаргана.
- 4.3. Сургалтын орчинд онцгой анхаарч, сургах орчин гэдэгт сайхан барилгаас илүү цогц орчин байх чиглэлд дүүрэг бүрд 1-2 сургууль сонгон жишиг сургууль төслийг эхлүүлнэ.
- 4.4. Эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудын эмчилгээ, үйлчилгээнд онцгой анхаарч, эмнэлгийн үйлчилгээний соёл төлөвшүүлэх 4 жилийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.
- 4.5. Боловсролын чанарын ялгааг арилгахын тулд улсын сургуулиудын чанар, менежементийг сайжруулах “менежментийн удирдлага” хөтөлбөрийг туршилтаар хэрэгжүүлнэ.

